



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны А/25 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн шилжүүлсэн нийт 34,654,500.00 (гучин дөрвөн сая зургаан зуун тавин дөрвөн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 2,036,810.20 (хоёр сая гучин зургаан мянга найман зуун арван төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө, газар эзэмших эрхийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Алтангэрэл, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Мөнхзул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002334

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 05 дугаар сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар албан бичгийн хавсралт



**Увс аймгийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч “Улаангомын дулааны хоёрдугаар станц”  
 төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Уурын зуухны барилга	2009	ш	1	22,992,600.00	22,992,600.00	1,916,050.10	21,076,549.90
2	Нүүрсний агуулах	2009	ш	1	301,900.00	301,900.00	120,760.10	181,139.90
3	Газар эзэмших эрх	2018	м.кв	568	20,000.00	11,360,000.00	-	11,360,000.00
<b>Нийт дүн</b>						34,654,500.00	2,036,810.20	32,617,689.80
						(гучин дөрвөн сая зургаан зуун тавин дөрвөн мянга таван зуун мянган)		(гучин хоёр сая зургаан зуун арван долоон мянга зургаан зуун наян есөн төгрөг наян мөнгө)